



**МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ**

2008 оны 03 сарын 28 өдөр

Дугаар 61

Улаанбаатар хот

“Ердийн даатгал, давхар даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам” батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15.3.2, 15.3.3, Даатгалын тухай хуулийн 13.1.3, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 5.1.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Ердийн даатгал, давхар даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ыг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2. Энэ журам гарсантай холбогдуулан Хорооны 2006 оны 19 дүгээр тогтоолоор батлагдсан “Ердийн даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам” болон уг журамд нэмэлт оруулах тухай Хорооны 2007 оны 134 дүгээр тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Даатгалын газар /С.Ганболд/, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /Б.Мөнхжаргал/-г тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

**ЕРДИЙН ДААТГАЛ, ДАВХАР ДААТГАЛЫН БОЛОН ДААТГАЛЫН  
МЭРГЭЖЛИЙН ОРОЛЦОГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ  
ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ЖУРАМ**

**НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

1.1. Энэхүү журмын зорилго нь Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “Хороо” гэх)-ноос ердийн даатгал, давхар даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээд, хувь хүнд тусгай зөвшөөрөл олгох, компанийн салбар байгуулах, дүрмийн сангийн бүтэц, хэмжээнд өөрчлөлт оруулах, оноосон нэрийг солих зөвшөөрөл олгох харилцааг зохицуулахад оршино.

1.2. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 5.3-т заасны дагуу тусгай зөвшөөрлийг бусдад худалдах, бэлэглэх, барьцаалах зэргээр бусдад шилжүүлж үл болно.

1.3. Ердийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн даатгалын хэлбэрт хамаарах даатгалын бүтээгдэхүүнийг Хороонд бүртгүүлнэ. Хороонд бүртгүүлээгүй бол тухайн даатгалын бүтээгдэхүүнийг худалдан борлуулахыг хориглоно. *Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2009 оны 1 дүгээр сарын 29-ний өдрийн 17 дугаар тогтоолоор нэмсэн/*

**ХОЁР. ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ**

**А. ЕРДИЙН ДААТГАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ТУСГАЙ  
ЗӨВШӨӨРӨЛӨЛГӨХӨД ТАВИГДАХ ШААРДЛАГА,  
БҮРДҮҮЛЭХ БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ**

***Ердийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл  
олгохыг хүссэн хуулийн этгээдэд тавигдах шаардлага***

2.1. Даатгалын компанийг хувьцаат компани (ХК), эсхүл хязгаарлагдмал хариуцлагатай компани (ХХК) хэлбэрээр байгуулсан байх.

2.2. Даатгалын компанийг ХК хэлбэрээр байгуулах тохиолдолд энэ журмын 2.11-д заасан баримт бичгийг бүрдүүлэн Хороонд ирүүлж, Хороо тусгай зөвшөөрөл олгохоор шийдвэрлэсний дараа Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 5-9-д заасны дагуу үнэт цаасаа Хороонд бүртгүүлэх.

2.3. Компанийн дүрмийн санг Даатгалын тухай хуулийн 22.1-д заасан шаардлагад нийцүүлсэн байх.

2.4. Даатгалын үйл ажиллагааны 3-аас доошгүй жилийн бизнес төлөвлөгөөтэй байх.

2.5. Даатгалын тухай хуулийн 20.10 болон Хорооны 2007 оны 193 дугаар тогтоолоор батлагдсан “Даатгагчийн болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тохиромжтой этгээдийг тодорхойлох заавар”-т заасан тохиромжтой этгээдийн шаардлагыг хангасан, даатгагчийн шийдвэр гаргахад нөлөөлөхүйц албан тушаал эрхэлдэггүй хувь нийлүүлэгчтэй байх.

2.6. Даатгалын тухай хуулийн 20.10 болон Хорооны 2007 оны 193 дугаар тогтоолоор батлагдсан “Даатгагчийн болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тохиромжтой этгээдийг тодорхойлох заавар”-т заасан тохиромжтой этгээдийн шаардлагыг хангасан удирдах ажилтантай байх.

2.7. Зах зээлд нийлүүлэх 2-оос доошгүй бүтээгдэхүүнтэй байх.

2.8. Компанийн үйл ажиллагааг хэвийн явуулах ажлын байртай байх.

2.9. Даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг нь хүчингүй болгосон компанийн нэртэй ижил нэр, лого, хэвлэмэл хуудас, даатгалын гэрээ, даатгалын гэрээний баталгаа зэргийг ашиглаагүй байх.

2.10. Компанийн хувь нийлүүлэгчид нь өөр аль нэг даатгалын компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (ГУЗ)-ийн дарга, гишүүн, хамтын гүйцэтгэх удирдлагын гишүүн, эрх бүхий албан тушаалд томилогдон ажиллаагүй байх.

***Ердийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгохыг хүссэн хуулийн этгээдээс бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт***

2.11. Компани байгуулж, даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгохыг хүссэн хуулийн этгээд нь Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11.1 болон Даатгалын тухай хуулийн 19-т тус тус заасны дагуу дараах баримт бичгийг бүрдүүлж Хороонд ирүүлнэ. Үүнд:

2.11.1. Ердийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгохыг хүссэн өргөдлийг энэхүү журмын 1 дүгээр хавсралтын дагуу гаргана;

2.11.2. Нэгээс дээш үүсгэн байгуулагч нийлж компанийг байгуулж байгаа бол компани байгуулж, ердийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх тухай хувь нийлүүлэгчдийн хурлын шийдвэрийн эх хувь, эсхүл нотариатаар гэрчлүүлсэн хуулбар, нэг үүсгэн байгуулагчтай бол компани үүсгэн байгуулах шийдвэр, улсын бүртгэлийн гэрчилгээний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар;

2.11.3. Улсын бүртгэлийн албанд бүртгүүлсэн компанийн дүрмийн нотариатаар гэрчлүүлсэн хуулбар (уг дүрмэнд компанийн дүрмийн сангийн хэмжээ, бүтэц, эрхлэх даатгалын ангилал, төрөл хэлбэрийг тодорхой тусгасан байх);

2.11.4. Энэ журмын 5 дугаар хавсралтад дурьдсан зөвлөмжийн дагуу боловсруулсан бизнес төлөвлөгөө;

2.11.5. Тусгай зөвшөөрөл олгохыг хүссэн даатгалын бүтээгдэхүүн тус бүрээр боловсруулсан журам, даатгалын гэрээ болон гэрээний баталгааны загвар. Даатгалын гэрээ болон гэрээний баталгаанд Иргэний хуулийн 431 дүгээр зүйлд зааснаас гадна даатгалын нөхөн төлбөр олгох нөхцөл, түүнийг шийдвэрлэх хугацааг нэмж тусгана;

2.11.6. Даатгалын тухай хуулийн 14.2.5 болон Хорооны 2007 оны 190 дүгээр тогтоолоор батлагдсан “Даатгалын хэмжээ, даатгалын хураамжийн хэмжээг тооцох аргачлал”-д заасны дагуу тооцоолол хийсэн хураамжийн хувь хэмжээний тооцоолол, танилцуулга;

2.11.7. Хууль тогтоомжид заасан дүрмийн сангийн доод хэмжээг тусгасан эхлэлтийн тайлан, компанийн дүрмийн санд хувь нийлүүлэгч нарын оруулсан мөнгөн хөрөнгийн эх үүсвэр нь хууль ёсны орлогоос бүрдсэн болохыг нотлох баримт бичиг;

2.11.8. Энэ журмын 2 дугаар хавсралтын дагуу гаргасан үүсгэн байгуулагч, хувь нийлүүлэгч, ТУЗ-ийн дарга, гишүүдийн тодорхойлолт болон энэ журмын гуравдугаар хавсралтын дагуу гаргасан захирал, даатгалын ахлах менежер, ерөнхий нягтлан бодогчийн тодорхойлолт;

2.11.9. Энэ журмын дөрөвдүгээр хавсралтаар гаргасан техник тоног төхөөрөмж, программ хангамжийн жагсаалт, ажлын байрны үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ, эсхүл түрээсийн гэрээний хуулбар;

2.11.10. Бусад баримт бичиг (шаардлагатай тохиолдолд мөнгө угаах, алан хядах ажиллагааг санхүүжүүлэхтэй холбогдсон эсэх тухай болон компанийн хувь нийлүүлэгчид, эрх бүхий албан тушаалтны ял шийтгэлтэй эсэх тухай цагдаагийн байгууллагын тодорхойлолт зэрэг).

#### **Б. ДАВХАР ДААТГАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХОД ТАВИГДАХ ШААРДЛАГА, БҮРДҮҮЛЭХ БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ**

2.12. Давхар даатгалын компани байгуулахад энэ журмын 2 дугаар бүлгийн А хэсэгт заасан ердийн даатгагчид тавигдах шаардлага нэгэн адил хамаарахбөгөөд энэ журмын 2.11-д заасны дагуу баримт бичгийг бүрдүүлнэ.

Давхар даатгалын компанийн алдагдлаас хамгаалах сан нь 5 тэрбум төгрөгөөс доошгүй хэмжээтэй байна. Энэхүү хэмжээг Хороо давхар даатгалын үйл ажиллагааны шинж чанар, цар хүрэнээс хамааран нэмэгдүүлэн тогтоож болно. Сангийн мөнгөн хөрөнгийн зарцуулалт, зохицуулалттай холбоотой журмыг Хороо батална. *[Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн 213 дугаар тогтоолоор нэмсэн/*

2.13. Давхар даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан компани нь зөвхөн давхар даатгалын үйл ажиллагааг дагнан эрхэлнэ.

2.14. Давхар даатгалын мэргэжилтэн, актуарч болон андеррайтертэй байна.

2.15. Хамтран ажиллах тэргүүлэгч давхар даатгагч болон брокер нарын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг гаргаж Хороонд ирүүлэх бөгөөд тэдгээр нь “Стандарт энд Пуэрс” (Standard and Poors)-ээс өгсөн үнэлгээний “BBB” буюу түүнтэй тэнцэх хэмжээний үнэлгээнээс дээш үнэлгээ авсан байвал зохино.

2.16. Үйл ажиллагааны онцлогтой холбоотойгоор нарийвчилсан тодруулга болон нэмэлт материалыг Хороо шаардаж болно.

#### **В. ДААТГАЛЫН МЭРГЭЖЛИЙН ОРОЛЦОГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХОД ТАВИГДАХ ШААРДЛАГА, БҮРДҮҮЛЭХ БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ**

##### ***Даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход тавих шаардлага, бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт***

2.17. Даатгалын зуучлагч компанийг байгуулсан, эсхүл Монголбанкнаас олгосон тусгай зөвшөөрөл бүхий банк байх, эсхүл түүний хараат болон охин компани */Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2010 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн 202 дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан/* */Энэ хэсэгт Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 387 дугаар тогтоолоор өөрчлөлт орсон/*

2.18. Даатгалын зуучлагч хуулийн этгээдийн дүрмийн санг зээлийн хөрөнгөөр бүрдүүлэхийг хориглох бөгөөд дүрмийн сангийн мөнгөн хөрөнгийн доод хэмжээ нь 20 сая төгрөг, давхар даатгалын зуучлалын үйл ажиллагаа эрхлэх тохиолдолд 50.0 сая төгрөг байна. */Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2010 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн 202 дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан/*  
*/Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 387 дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан/*

2.19. Компанийн үйл ажиллагааны 1-ээс доошгүй жилийн бизнес төлөвлөгөөтэй байх.

2.20. Өргөдөл гаргагчийн үүсгэн байгуулагч, хувь нийлүүлэгч болон удирдах ажилтнууд нь даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх тохиромжтой этгээд байх. */Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2010 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн 202 дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан/*

~~2.21. Даатгалын тухай хуулийн 6.1-д заасан ангилалын дагуу урт хугацааны даатгал, эсхүл ердийн даатгалын зуучлалын аль нэгийг эрхлэх. Эрхлэх даатгалын хэлбэрээ тодорхойлсон байх.~~  
*/Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 387 дугаар тогтоолоор хассан/*

2.22. Дүрмийн сангийн мөнгөн хөрөнгийн эх үүсвэр, гарал үүслийг нотлосон байх. */Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2010 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн 202 дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан/*

2.23. Компанийн үйл ажиллагааг хэвийн явуулах ажлын байртай байх.

2.23<sup>1</sup>. Өргөдөл гаргагч нь энэ журмын 2.17-д заасан Монголбанкнаас олгосон тусгай зөвшөөрөл бүхий банк, түүний хараат болон охин компани бол энэ журмын 2.17-2.2.26<sup>1</sup>-д заасан шаардлагыг хангахаас гадна дараах нэмэлт шаардлагыг хангана:  
*/Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 387 дугаар тогтоолоор нэмсэн/*

2.23<sup>1</sup>.1. Банк нь даатгалын зуучлалын үйл ажиллагааг хариуцах тусгайлсан нэгжтэй байх бөгөөд энэхүү нэгжийг тухайн банкны Төлөөлөн удирдах зөвлөл эсхүл гүйцэтгэх захирлын шийдвэрээр байгуулсан байх; */Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 387 дугаар тогтоолоор нэмсэн/*

2.23<sup>1</sup>.2. Даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа явуулах нэгжийн удирдах албан тушаалтан болон ажилтнууд нь холбогдох мэргэжлийн холбоод эсхүл хамтран ажиллах даатгагчаас зохион байгуулсан даатгалын сургалтад хамрагдаж, Хороо болон Хорооны орон нутгийн төлөөлөгчийн зохион байгуулсан даатгалын зуучлалын шалгалтад тэнцсэн байх;” */Энэхүү заалтыг 2013 оны 3 дугаар сарын 1-ний өдрөөс дагаж мөрдөнө./* */Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 387 дугаар тогтоолоор нэмсэн/*

2.24. Даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэхийг хүсэгч нь энэ журмын 2.11.1-2.11.4, 2.11.7-2.11.10-г заасан баримт бичгийг бүрдүүлж Хороонд ирүүлнэ. */Энэ хэсэгт Санхүүгийн зохицуулах хорооны 2010 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн 202 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан/*

2.24<sup>1</sup>. Өргөдөл гаргагч нь банк бол энэ журмын 2.24 дэх хэсэгт зааснаас гадна дараах баримт бичгийг ирүүлнэ: */Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 387 дугаар тогтоолоор нэмсэн/*

2.24<sup>1</sup>.1. Хоёроос доошгүй даатгалын компанитай байгуулах хамтран ажиллах гэрээний төсөл. Хамтран ажиллах гэрээний төсөлд дараах зүйлийг тусгана:

2.24<sup>1</sup>.1.1. Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 26.1 дэх хэсэгт заасны дагуу даатгалын хураамжийн орлогыг даатгагчийн дансанд шуурхай шилжүүлэх ажиллагааны зохицуулалт;

2.24<sup>1</sup>.1.2. хамтран ажиллах даатгагч бүрийн нэр дээр данс нээх талаарх зохицуулалт;

2.24<sup>1</sup>.1.3. даатгалын хураамж төлөгдсөнөөр даатгалын гэрээ байгуулагдсанд тооцож, даатгалын тохиолдол гарахад даатгалын хураамжийн орлого даатгагчийн дансанд шилжсэн эсэхээс үл хамааран даатгагч даатгуулагчид нөхөн төлбөр олгох талаарх зохицуулалт;

2.24<sup>1</sup>.2. даатгалын зуучлалын үйл ажиллагаа эрхлэхтэй холбоотой дотоод журмын төсөл. /тус журмын төсөлд даатгалын зуучлалын үйл ажиллагааг эрхлэх дотоод бүтэц, чиг үүрэг, хариуцлага, тайлагнал, төлбөр тооцооны асуудлыг зохицуулахаар тусгасан байна.

2.25<sup>1</sup>. Хэрэв өргөдөл гаргагч нь банк түүний хараат болон охин компани бол Банкны тухай хуулийн 6.4-т заасны дагуу даатгалын зуучлагчийн үйл ажиллагааг эрхлэхэд татгалзахгүй тухайгаа мэдэгдэж Монголбанкнаас Хороонд ирүүлсэн албан бичиг.

*/Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2010 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн 202 дугаар тогтоолоор нэмсэн/*

*/Энэ хэсэгт Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 387 дугаар тогтоолоор нэмэлт оруулсан./*

2.26<sup>1</sup>. Даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч нь даатгалд жил бүр даатгуулах ба мэргэжлийн хариуцлагын даатгалын хэмжээний доод хязгаар 50.0 сая төгрөг байна. */Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2010 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн 202 дугаар тогтоолоор нэмсэн/*

2.27<sup>1</sup>. Даатгалын зуучлалын үйл ажиллагааг банк болон банкны салбараар дамжуулан хийх бөгөөд банк нь Хорооноос авсан салбарын зөвшөөрөлгүйгээр аймаг, орон нутагт даатгалын зуучлалын үйл ажиллагаа явуулахыг хориглоно. */Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 387 дугаар тогтоолоор нэмсэн/*

2.28<sup>1</sup>. Даатгалын зуучлалын үйл ажиллагааг хариуцсан удирдах албан тушаалтан нь Хороонд даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэхтэй холбоотой тайлан мэдээг гаргаж өгөх, даатгалын зуучлалын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах, зохион байгуулах чиг үүрэгтэй байна. */Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 387 дугаар тогтоолоор нэмсэн/*

2.29<sup>1</sup>. Даатгалын зуучлалын үйл ажиллагаа эрхэлж буй банк нь орон нутагт тусдаа данстай байхыг хориглоно. */Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 387 дугаар тогтоолоор нэмсэн/*

***Даатгалын хохирол үнэлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход тавих шаардлага, бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт***

2.25. Энэ журмын 2.1, 2.3-2.6, 2.8, 2.10-т заасан шаардлагыг хангасан байх. Даатгалын хохирол үнэлэгч компанийн дүрмийн сангийн доод хэмжээ Улаанбаатар хотод 10,0 (арван) сая төгрөг, хөдөө орон нутагт 7,0 (долоон) сая төгрөг байна.

2.26. Даатгалын хохирлын үнэлгээ хийх ажилтан нь даатгалын болон даатгалын хохирлын үнэлгээ хийх чиглэлээр сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан байх.

2.27. Даатгалын хохирлын үнэлгээ хийх ажилтан нь даатгалын, эсхүл даатгалын хохирлын үнэлгээний чиглэлээр 3-аас доошгүй жилийн ажлын дадлага туршлагатай байх.

2.28. Даатгалын хохирол үнэлэгчийн үйл ажиллагаа явуулах компани нь тухайн чиглэлийн үйл ажиллагааг хийж гүйцэтгэхэд шаардлагатай судалгааны материал болон холбогдох баримт бичгүүдтэй байх. Даатгалд жил бүр даатгуулах ба мэргэжлийн хариуцлагын даатгалын хэмжээний доод хязгаар 50,0 (тавин) сая төгрөг байх.

2.29. Даатгалын хохирол үнэлэгчийн үйл ажиллагаа эрхлэх чиглэлээ даатгалын хэлбэрээр гаргасан байх.

2.30. Даатгалын хохирол үнэлэгчийн үйл ажиллагаа эрхлэхийг хүсэгч нь энэ журмын 2.11.1-2.11.4, 2.11.7-2.11.10-д заасан материал болон хохирол үнэлэгчид тавих шаардлагыг хангаж буйг харуулсан бусад баримт бичгүүдийг бүрдүүлж Хороонд ирүүлнэ.

2.30<sup>1</sup>. Орон нутагт салбараар дамжуулан даатгалын зуучлалын үйл ажиллагаа эрхэлж буй даатгалын зуучлагч нь тухайн орон нутагт Хорооноос салбар нээх зөвшөөрөл аваагүй даатгагчтай хамтран ажиллахыг хориглоно./Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн 240 дүгээр тогтоолоор нэмсэн/

2.31. Хороо шаардлагатай гэж үзвэл нэмэлт материалыг шаардаж болно.

***Даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл  
олгоход тавих шаардлага, бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт***

2.32. Даатгалын сургалтанд хамрагдаж, гэрчилгээ авсан байх. Даатгалын төлөөлөгч нь хэрэв хуулийн этгээд бол даатгалын төлөөлөгчөөр ажиллах ажилтнууд нь энэхүү шаардлагыг хангасан байх.

2.33. Даатгалын тухай хуулийн дагуу даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан даатгагчаас олгосон даатгалын төлөөлөгчөөр ажиллах зөвшөөрөлтэй байх.

2.34. Даатгагчтай хамтран ажиллах гэрээтэй байх.

2.35. Даатгалын төлөөлөгчөөр ажиллах этгээд нь төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд, аж ахуй нэгж болон Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 3.1.4-т заасан “нийтийн албан тушаалтан” биш байх./Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн 158 дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан/

2.36. Даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгохыг хүссэн өргөдлийг энэ журмын 6 дугаар хавсралтын дагуу гаргаж, энэ журмын 2.32-2.35-д заасан шаардлагыг хангасан нотолгоо баримт бичгийн хамт ирүүлнэ.

2.37. Энэ журмын 3 дугаар хавсралтын дагуу даатгалын боловсон хүчний тодорхойлолтыг иргэний үнэмлэхийн нотариатаар гэрчлүүлсэн хуулбарын хамт ирүүлнэ. Төлөөлөгч нь хэрэв байгууллага бол төлөөлөгчийн үйл ажиллагааг эрхлэх этгээд нь энэхүү тодорхойлолтыг байгууллагын танилцуулгын хамт гаргаж ирүүлнэ.

2.38. Гадаадын иргэн Монголын даатгалын компанийн төлөөлөгчөөр ажиллах бол нэмэлт материал Хороо шаардаж болно. Гадаадын даатгагчийн төлөөлөгчийг Монголд ажиллуулах асуудлыг Даатгалын тухай хуулийн 14.2.11 дэх заалтын дагуу Хорооноос баталсан журмаар зохицуулна.

2.38<sup>1</sup>. Санхүүгийн зохицуулах хорооноос хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан хуулийн этгээд нь даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхэлж болох бөгөөд дараах шаардлагыг хангасан байна: */Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн 240 дүгээр тогтоолоор нэмсэн/*

2.38<sup>1</sup>.1. Даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх хадгаламж, зээлийн хоршоо нь тус хоршооны гишүүдээс бусад этгээдэд даатгалын гэрээ борлуулахгүй байх;

2.38<sup>1</sup>.2. Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасан хоршооны дүрмийн эрхлэх үйл ажиллагааны төрөлд даатгалын төлөөлөгчийн тусгай зөвшөөрлийн үйл ажиллагаа эрхлэх зохицуулалтыг тусгасан байх;

2.38<sup>1</sup>.3. Даатгагчтай хамтран ажиллах гэрээтэй байх; /Хамтран ажиллах гэрээнд хадгаламж, зээлийн хоршоо нь даатгалын хураамжийн орлогыг даатгагчид ямар хугацааны дотор хэрхэн шилжүүлэх талаар тодорхой тусгасан байх/

2.38<sup>1</sup>.4. Хадгаламж, зээлийн хоршоо нь даатгагчаас олгосон даатгалын төлөөлөгчөөр ажиллах зөвшөөрөлтэй байх;

2.38<sup>1</sup>.5. Хоршоог төлөөлж даатгалын гэрээ борлуулах хоршооны гүйцэтгэх захирал болон гүйцэтгэх удирдлагын орон тооны албан тушаалтан нь даатгалын сургалтад хамрагдаж, даатгалын төлөөлөгчийн шалгалтад тэнцсэн байх.

2.38<sup>2</sup>. Даатгалын төлөөлөгчийн тусгай зөвшөөрлийн үйл ажиллагаа эрхлэхийг хүссэн хадгаламж, зээлийн хоршоо нь дараах баримт бичгийг Хороонд ирүүлнэ: */Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн 240 дүгээр тогтоолоор нэмсэн/*

2.38<sup>2</sup>.1. Энэ журмын 10 дугаар хавсралтын дагуу гаргасан хүсэлт;

2.38<sup>2</sup>.2. Даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх тухай шийдвэрлэсэн хоршооны тэргүүлэгчдийн хурлын шийдвэр;

2.38<sup>2</sup>.3. Санхүүгийн зохицуулах хорооноос олгосон хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбар;

2.38<sup>2</sup>.4. Хамтран ажиллахыг зөвшөөрсөн даатгагчийн албан бичиг;

2.38<sup>2</sup>.5. Даатгагчтай хамтран ажиллах гэрээний төсөл;

2.38<sup>2</sup>.6. Даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх зохицуулалтыг тусгасан дүрмийн төсөл;

2.38<sup>2</sup>.7. Даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагааг эрхлэхтэй холбогдсон журмын төсөл;

2.38<sup>2</sup>.8. Тухайн хоршооны талаарх танилцуулга.



## **Г. ЕРДИЙН ДААТГАЛ, ДАВХАР ДААТГАЛЫН БОЛОН ДААТГАЛЫН МЭРГЭЖЛИЙН ОРОЛЦОГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ, ОЛГОХООС ТАТГАЛЗАХ**

2.39. Ердийн даатгал, давхар даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл (цаашид “даатгалын тусгай зөвшөөрөл” гэх) олгохыг хүсч, үүсгэн байгуулагчдаас ирүүлсэн баримт бичгийг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11, 12, Даатгалын тухай хуулийн 20.1, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 11.1 дэх заалтууд болон энэ журмыг үндэслэн хянаж, шаардлагатай асуудлыг газар дээр нь шалгасны үндсэн дээр тусгай зөвшөөрөл олгох асуудлыг Хорооны хуралдаанд оруулж шийдвэрлүүлнэ.

2.40. Хороо Даатгалын тухай хуулийн 20.7 болон Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 11.6-д заасны дагуу ажлын 45 хоногийн дотор тусгай зөвшөөрөл олгох эсэхийг шийдвэрлэнэ. Энэ хугацааг даатгалын зөвшөөрөл хүссэн баримт бичгийг үнэн зөв, бүрэн гүйцэд бүрдүүлж Хороонд ирүүлсэн өдрөөс эхлэн шийдвэрлэх хугацааг тооцно.

2.41. Хороо даатгалын тусгай зөвшөөрөл олгохоор шийдвэрлэсний дараа компани дүрмийн сангийн мөнгөн хөрөнгийг Хорооны хяналтанд байх дансанд түр байршуулах ба энэ тухай мэдэгдлийг Хороо бичгээр өгнө.

2.42. Компани уг албан бичгийг хүлээн авснаас хойш ажлын 3 хоногийн дотор компанийн дүрмийн сангийн мөнгөн хөрөнгийг Хорооны хяналтанд байх дансанд хуанлийн 10 хоногийн хугацаатай байршуулах ба энэхүү мөнгөн хөрөнгөнд Хороо хүү төлөхгүй.

2.43. Даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох Хорооны шийдвэрт тухайн хуулийн этгээдэд ямар ангилал, төрөл, хэлбэрийн даатгалын үйл ажиллагааг эрхлэх зөвшөөрөл олгосныг тусгана.

2.44. Энэ журмын 2.48-д заасан Хорооны шийдвэр болон Хорооноос баталсан “Даатгалын компани болон даатгалын мэргэжлийн оролцогчоос төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ”-нд зааснаар холбогдох хураамжийг төлсөн баримтыг үндэслэн тухайн хуулийн этгээдэд Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 3.1.3, 3.1.4-д заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн гэрчилгээг олгоно.

2.45. Даатгалын тусгай зөвшөөрөл олгогдсон хуулийн этгээдийн гүйцэтгэх удирдлага Хорооны хяналтанд байх дансанд түр байршуулсан мөнгөн хөрөнгийг өөрийн харилцах дансанд шилжүүлж авах тухай хүсэлтээ албан ёсоор Хороонд тавина.

2.46. Хороо нь тухайн хуулийн этгээдийн тусгай зөвшөөрлийг бүртгэн авч, зохих зааврын дагуу нэгдсэн бүртгэлд бүртгэнэ.

2.47. Хорооноос даатгалын тусгай зөвшөөрөл авсан хуулийн этгээд нь компанийн дүрэм, бусад баримт бичигт орсон өөрчлөлтийг Улсын бүртгэлийн албанд бүртгүүлнэ.

2.48. Компани нь Хорооноос олгосон тусгай зөвшөөрөлтэйгээр үйл ажиллагаа явуулж эхэлснээс хойших хугацаанд тусгай зөвшөөрөл авахаар бүрдүүлж ирүүлсэн баримт бичигт өөрчлөлт орсон тухайн бүрд уг өөрчлөлтийн талаарх мэдээллийг ажлын 10 хоногийн дотор Хороонд ирүүлнэ.

2.49. Хороо нь дараах үндэслэлээр даатгалын тусгай зөвшөөрөл олгохоос татгалзана. Үүнд:

2.49.1. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11 болон энэ журамд заасан шаардлагыг хангаагүй;

2.49.2. Хуурамч баримт бичиг бүрдүүлсэн нь нотлогдсон;

2.49.3. Хувь нийлүүлэгчид санхүүгийн зах зээлд оролцогчийн хувьд буюу шунахай зорилгоор гэмт хэрэг үйлдэж, шийтгэгдсэн нь тогтоогдсон, эсхүл ял шийтгэлгүйд тооцох хугацаа дуусаагүй гэсэн мэдээлэл ирсэн буюу мэдэгдсэн, тогтоогдсон;

2.49.4. Хорооноос даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг нь хүчингүй болгосон өдрөөс хойш 3 жил болоогүй;

2.49.5. Бусад хууль, журамд заасан шаардлагыг хангаагүй.

2.50. Даатгалын тусгай зөвшөөрөл олгохоос татгалзсан тохиолдолд Хороо энэ талаарх үндэслэл бүхий тайлбарыг өргөдөл гаргагчид албан тоот бичгээр мэдэгдэнэ.

2.51. Хороо хуурамч баримт бичиг бүрдүүлсэн үндэслэлээр даатгалын тусгай зөвшөөрөл олгохоос татгалзсан тохиолдолд энэ хугацаанаас хойш 2 жилийн дотор тухайн компанийн хувь нийлүүлэгчид, гүйцэтгэх удирдлага (гүйцэтгэх захирал, даатгалын менежер, ерөнхий нягтлан бодогч, эсхүл тэдгээртэй адилтгах албан тушаал)-д ажиллах этгээдээс даатгалын тусгай зөвшөөрөл хүссэн хүсэлтийг дахин хүлээн авахгүй.

2.52. Хороо тусгай зөвшөөрөл олгосон тухайгаа нийтэд мэдээлнэ.

## **ГУРАВ. ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ**

### **А. ДААТГАЛЫН БАЙГУУЛЛАГЫН ДҮРМИЙН САНГИЙН ХЭМЖЭЭ, БҮТЦЭД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХАД ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ, БҮРТГЭХ**

3.1. Компани нь дүрмийн сангийнхаа өөрчлөлтийн талаар тухайн бүрд Хороонд мэдэгдэж, зөвшөөрөл авч байна. Зөвшөөрлийг авахдаа эдгээр өөрчлөлтийн дагуу аливаа гүйлгээ, төлбөр хийхээс өмнө дараах бичиг баримтыг Хороонд ирүүлнэ. Үүнд:

3.1.1. Өргөдөл (өөрчлөлт оруулах болсон үндэслэл, тайлбарыг оруулах);

3.1.2. Компанийн шинэ хувь нийлүүлэгч нь Даатгалын тухай хуулийн 20.10 болон Хорооны 2007 оны 193 дугаар тогтоолоор батлагдсан “Даатгагчийн болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тохиромжтой этгээдийг тодорхойлох заавар”-т заасан тохиромжтой этгээдийн шаардлагыг болон даатгагчийн ашиг сонирхолд нөлөөлөхүйц албан тушаал эрхэлдэггүй гэсэн шаардлагыг хангасан талаарх баримт бичиг;

3.1.4. Шинэ хувь нийлүүлэгчийн тодорхойлолт (энэхүү журмын 2 дугаар хавсралтын дагуу гаргах);

3.1.5. Дүрмийн сангийн хэмжээ, бүтцийг өөрчилсөнтэй холбогдуулан компанийн дүрэмд орох нэмэлт өөрчлөлт (дүрэм өөрчлөгдөх шаардлагатай бол);

3.1.6. Дүрмийн санд оруулсан хөрөнгө нь мөнгө угаах, алан хядах ажиллагааг санхүүжүүлэхтэй холбогдсон сэжиг бүхий гэж үзвэл Хороо нэмэлт мэдээлэл шаардаж болно;

3.1.7. Хувьцаат компанийн хэлбэрээр байгуулагдсан компанийн хувьд хувьцааны эзэмшигч өөрчлөгдсөн тухай Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төвөөс ирүүлсэн тодорхойлолт, хувьцаа эзэмшигчийн дансны үлдэгдэл бүхий хуулга.

3.2. Дүрмийн сангийн хэмжээ, бүтцэд өөрчлөлт оруулах зөвшөөрөл олгохыг хүсч ирүүлсэн хүсэлт, холбогдох баримт бичгийг холбогдох хууль тогтоомжийн заалтыг үндэслэн хянаж, шаардлагатай гэж үзвэл газар дээр нь шалгасны үндсэн дээр Даатгалын газраас санал дүгнэлт гарган Хорооны удирдлагад танилцуулна. Хорооны дарга холбогдох хууль тогтоомжийг үндэслэн шийдвэр гаргана.

3.3. Компанийн дүрмийн сангийн хэмжээ, бүтцэд өөрчлөлт оруулахад зөвшөөрөл олгох эсэхийг ажлын 10 хоногийн дотор шийдвэрлэнэ. Энэ журмын 3.2-т заасан шийдвэр гарсны дараа компани дүрмийн санг нэмэгдүүлэх мөнгөн хөрөнгийг Хорооны хяналтанд байх дансанд түр байршуулах ба энэ тухай мэдэгдлийг Хороо компанид албан бичгээр мэдэгдэнэ.

3.4. Компани нь тус албан бичгийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 3 хоногийн дотор компанийн дүрмийн санг нэмэгдүүлсэн мөнгөн хөрөнгийг Хорооны дансанд шилжүүлж уг дансанд хуанлийн 10 хоногийн хугацаатай байршуулах ба энэхүү мөнгөн хөрөнгөд Хороо хүү төлөхгүй.

## Б. ДААТГАЛЫН БАЙГУУЛЛАГЫН САЛБАР БАЙГУУЛАХ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ, ХҮЧИНГҮЙ БОЛГОХ

3.5. Даатгалын байгууллага гэдэгт даатгалын компани, давхар даатгалын компани, даатгалын хохирол үнэлэгчийн болон зуучлагчийн үйл ажиллагаа эрхэлдэг компаниудыг ойлгоно.

3.6. Даатгалын байгууллага нь салбартай байж болох бөгөөд салбар нээх, татан буулгах зөвшөөрлийг Хорооноос авна.

3.7. Даатгалын байгууллагын салбар нь зөвхөн тухайн даатгалын байгууллагын оноосон нэрийг хэрэглэх ба салбарын эрхлэх үйл ажиллагааны хүрээ, ажиллах журмыг даатгалын байгууллага өөрөө тогтооно.

3.8. Даатгалын байгууллагын салбар нь үйл ажиллагаа явуулах нутаг дэвсгэрийн хязгаарлалтаа тодорхойлсон, хаяг, байршил нь тодорхой, байнгын ажлын байртай, даатгалын мэргэшсэн удирдлагатай байхын зэрэгцээ санхүүгийн тайлан гарган төвдөө нэгтгүүлж, хянуулдаг байх шаардлагыг хангасан байна.

3.8<sup>1</sup>. Салбар нь 2-оос доошгүй орон тооны ажилтантай, арилжааны банкны салбарт өөрийн данстай байх бөгөөд даатгалын талаарх баримт бичгийг холбогдох хууль тогтоомжийн дагуу бүрдүүлж архивлахаас гадна даатгалын төлөөлөгч, даатгуулагч иргэдэд зориулан сургалт, сурталчилгаа хийж, даатгагчийн хувьд компанийн төвөөс зөвшөөрсөн хэмжээнд нөхөн төлбөрийг бие даан шуурхай олгодог байвал зохино. */Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 33 дугаар тогтоолоор нэмсэн/  
/Энэ хэсэгт Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 387 дугаар тогтоолоор нэмэлт оруулсан/*

3.8<sup>2</sup>. Даатгалын компанийн салбар нь жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын үйл ажиллагаа эрхлэх тохиолдолд шуурхай албатай байх ба 24 цагаар дуудлага хүлээн авах суурин утастай, тээврийн ослын хохирлын хэмжээг газар дээр нь очиж тогтоох зориулалтын автомашинтай, даатгалын талаарх мэдээлэл оруулж хадгалах, шаардлагатай мэдээг мэдээллийн санд өгч нэгтгүүлэх интернэтэд холбогдсон программ хангамжтай байх нөхцөлийг бүрдүүлсэн байна. */Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 33 дугаар тогтоолоор нэмсэн/  
/Энэ хэсэгт Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 387 дугаар тогтоолоор нэмэлт оруулсан/*

3.8<sup>3</sup>. Даатгалын салбарын захирал, ажилтан, гэрээт ажилтнаар ажиллах этгээд нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 3.1.4-т заасан “нийтийн албан тушаалтан” биш байх. */Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн 158 дугаар тогтоолоор нэмсэн/*

3.9. Даатгалын байгууллага нь салбар нээх хүсэлт гаргахдаа дараах баримт бичгийг бүрдүүлж Хороонд ирүүлнэ. Үүнд:

3.9.1. Салбар нээх тухай даатгалын байгууллагын хүсэлт, шийдвэрийн хамт;

3.9.2. Салбарын удирдлагын болон орон тооны ажиллагсдын тодорхойлолтыг гаргаж ирүүлэх (энэ журмын 3 дугаар хавсралтаар гаргах); */Энэ заалтад Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 33 дугаар тогтоолоор нэмэлт оруулсан/*

3.9.4. Салбарын үйл ажиллагааны жилийн төлөвлөгөө болон даатгалын төлөөлөгч, даатгуулагч иргэдэд зориулсан сургалт, сургалчилгаа явуулах жилийн ажлын төлөвлөгөө; */Энэ заалтад Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 33 дугаар тогтоолоор нэмэлт оруулсан/*

3.9.5. Салбарын үйл ажиллагаа явуулах орон байр (түрээслэх эсэх), үйл ажиллагаанд ашиглах тоног төхөөрөмж, ашиглах программ хангамж; Даатгалын компанийн салбар нь жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын үйл ажиллагаа эрхлэх тохиолдолд дараах баримт бичгийг нэмж ирүүлнэ:  
*/Энэ заалтад Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 387 дугаар тогтоолоор нэмэлт оруулсан./*

3.9.5<sup>1</sup>. Арилжааны банкны тухайн аймаг, орон нутаг дахь салбарт нээсэн даатгалын салбарын дансны дугаар; */Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 33 дугаар тогтоолоор нэмсэн/*

3.9.5<sup>2</sup>. Жолоочийн хариуцлагын даатгалын тохиолдлыг шалгах шуурхай албаны бүтэц, бүрэлдэхүүн, зохион байгуулалтын талаарх танилцуулга; */Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 33 дугаар тогтоолоор нэмсэн/*

3.9.5<sup>3</sup>. Салбарт ажилуулах суурин утасны дугаар, интернэтэд холбогдсон эсэх магадлал, тухайн аймаг, орон нутагт бүртгэлтэй голлох хэрэглэгчдийн суурин утасны жагсаалтын хуулбар; */Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 33 дугаар тогтоолоор нэмсэн/*

3.9.5<sup>4</sup>. Дуудлагын зориулалтын автомашины гэрчилгээний нотриатаар гэрчлүүлсэн хуулбар; */Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 33 дугаар тогтоолоор нэмсэн/*

3.9.5<sup>5</sup>. Мэдээллийн сангийн программ дээр ажиллах ажилтай холбогдох сургалтанд хамрагдсан талаарх танилцуулга; */Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 33 дугаар тогтоолоор нэмсэн/*

3.9.5<sup>6</sup>. Салбараас даатгалын нөхөн төлбөр олгохтой холбогдсон журмын төсөл; */Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 33 дугаар тогтоолоор нэмсэн/*

3.10. Хороо энэ журмын 3.11-д дурдсан баримт бичгийг хянан үзэж, салбар байгуулах нь тухайн хуулийн этгээдийн санхүүгийн чадварт сөргөөр нөлөөлөхгүй, үйлчлүүлэгчдэд хохирол учруулахгүй гэж үзсэн, боловсон хүчин, техник тоног төхөөрөмж нь тухайн салбарын үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөлийг хангаж байна гэж үзвэл зөвшөөрөл олгох шийдвэрийг Хорооны дарга гаргана.

3.11. Даатгалын байгууллага нь салбар нээх, татан буулгах, үйл ажиллагааг хязгаарлах, өөрчлөн байгуулах (нэгтгэх, нийлүүлэх, салгах, тусгаарлах, өөрчлөх), байршлыг нь өөрчлөх (хооронд нь солих, шилжүүлэх) тухай бүрд шийдвэр гаргаж, уг шийдвэрийг гаргасан өдрөөс хойш ажлын 3 хоногийн дотор Хороонд ирүүлж бүртгүүлнэ.

3.12. Хорооны даргын шийдвэр болон зохицуулалтын үйлчилгээний хөлс төлсөн баримтыг үндэслэн тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хавсралтанд салбарын талаарх тэмдэглэлийг хийж баталгаажуулна.

3.13. Даатгалын байгууллагын салбар байгуулах зөвшөөрлийг дараах үндэслэлээр хүчингүй болгож, тусгай зөвшөөрлийн гэрчилгээнд ажлын 5 хоногийн дотор энэ тухай тэмдэглэл хийнэ. Үүнд:

3.13.1. Даатгалын байгууллагын шийдвэрээр;

3.13.2. Хорооны шийдвэрээр;

3.13.3. Хууль тогтоомжид заасан бусад үндэслэл.

3.14. Даатгалын байгууллага нь салбарын зөвшөөрлийг хүчингүй болгосноос хойш 1 жилээс доошгүй хугацааны дараа салбар нээх хүсэлтийг дахин тавьж болно.

3.15. Гадаад улсад салбар байгуулах асуудлыг Даатгалын тухай хуулийн 14.2.10 болон 54-т заасан журмаар зохицуулна.

## В. ДААТГАЛЫН БАЙГУУЛЛАГЫН ОНООСОН НЭРИЙГ СОЛИХ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ

3.16. Даатгалын байгууллага оноосон нэрийг өөрчлөх тухай хүсэлтээ дараах баримт бичгийн хамт бүрдүүлж Хороонд ирүүлнэ. Үүнд:

3.16.1. Компанийн оноосон нэр өөрчлөх тухай Хувь нийлүүлэгчдийн хурлын шийдвэр;

3.16.2. Улсын бүртгэлийн албанаас авсан шинэ оноосон нэрийн тодорхойлолт;

3.16.3. Компанийн өөрчлөлт оруулсан дүрэм;

3.16.4. Бусад шаардлагатай баримт материал.

3.17. Хороо хүсэлтийг хянаж, нэрээ өөрчлөх нь үйлчлүүлэгчдэд сөргөөр нөлөөлөхгүй, төөрөгдүүлэхгүй гэж үзвэл тухайн хуулийн этгээдийн оноосон нэрийг өөрчлөхийг зөвшөөрсөн тухай шийдвэрийг Хорооны дарга гаргана.

3.18. Хорооны шийдвэр болон зохицуулалтын үйлчилгээний хөлс төлсөн баримтыг үндэслэн Хорооноос олгосон тусгай зөвшөөрлийн гэрчилгээг эргүүлэн авч, тусгай зөвшөөрлийн гэрчилгээг шинээр олгоно.

3.19. Компанийн өмнөх нэр дээр үүссэн эрх, үүрэг эрх залгамжлалын журмаар шинэ нэрээр үйл ажиллагаа явуулж буй хуулийн этгээдэд бүрэн шилжинэ.

## Г. ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ДАГУУ ЭРХЛЭХ ЕРДИЙН ДААТГАЛЫН ХЭЛБЭРТ НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ

3.20. Даатгалын байгуулга нэмэлт даатгалын ангилал, төрөл, хэлбэрийг эрхлэхийг хүссэн өргөдлийг энэхүү журмын 1 дүгээр хавсралтын дагуу энэ журмын 3.21-3.22-г заасан баримт бичгийн хамт гаргана.

*/Энэ хэсэгт Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 387 дугаар тогтоолоор нэмэлт оруулсан/*

3.21. Нэмэлт даатгалын хэлбэрийн журам, даатгалын гэрээ болон баталгааны нөхцөл, загвар.

3.22. Даатгалын тухай хуулийн 14.2.5 болон Хорооны 2007 оны 190 дүгээр тогтоолоор батлагдсан “Даатгалын хэмжээ, даатгалын хураамжийн хэмжээг тооцох аргачлал”-д заасны дагуу тооцоолол хийсэн хураамжийн хувь хэмжээний тооцоолол, танилцуулга.

3.23. Тухайн даатгалын хэлбэрийн зөвшөөрлийг олгох Хорооны тогтоол гарснаар зөвшөөрөл хүчин төгөлдөр болно.

3.24. Даатгалын компанийн эрхэлж буй даатгалын хэлбэрийн тусгай зөвшөөрлийг компанийн хүсэлтээр хүчингүй болгож хасалт хийх асуудлыг Хорооны хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлнэ.

3.25. Нэмэлт даатгалын хэлбэрийн зөвшөөрөл олгохын тулд Хорооноос уг даатгалын хэлбэртэй холбогдсон нарийн мэргэжлийн шинжээч ажиллуулах шаардлага тавьж болно. Энэ тохиолдолд даатгалын компани нь холбогдох мэргэжлийн шинжээчээр авч ажиллуулсан хүний тодорхойлолтыг тухайн мэргэжлээр их, дээд сургууль төгссөнийг нотлох дипломын хуулбарын хамт ирүүлнэ. */Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 33 дугаар тогтоолоор нэмсэн/*

#### Д. ДААТГАЛЫН БАЙГУУЛЛАГЫН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ГАЗАР НЭЭХ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ, ХҮЧИНГҮЙ БОЛГОХ

3.26. Даатгалын байгууллага нь даатгалын төлөөлөгчийн газар нээх, татан буулгах зөвшөөрлийг Хорооноос авна.

3.27. Даатгалын байгууллагын төлөөлөгчийн газар гэж тухайн даатгалын байгууллагын төлөөллийг хэрэгжүүлж, бусад хувь хүн, хуулийн этгээдтэй хамтран ажиллах гэрээ, хэлцэл хийх, олон нийтийг мэдээллээр хангах, даатгуулагч, иргэдэд зориулан сургалт, сурталчилгаа хийх, судалгаа шинжилгээний ажил хийх чиг үүрэг бүхий нэгжийг хэлнэ.

3.28. Даатгалын байгууллагын төлөөлөгчийн газар нь зөвхөн тухайн байгууллагын оноосон нэрийг хэрэглэх ба төлөөлөгчийн газрын эрхлэх үйл ажиллагааны хүрээ, ажиллах журмыг даатгалын байгууллага өөрөө тогтооно.

3.29. Даатгалын байгууллагын төлөөлөгчийн газар нь үйл ажиллагаа явуулах нутаг дэвсгэрийн хязгаарлалтаа тодорхойлсон, хаяг байршил нь тодорхой байнгын ажлын байртай, даатгалын мэргэшсэн боловсон хүчинтэй, даатгалын төлөөлөгчийн газрын үйл ажиллагааг хэвийн явуулахад шаардлагатай тоног төхөөрөмжтэй байх шаардлагыг тус тус хангасан байна.

3.30. Даатгалын байгууллага нь даатгалын төлөөлөгчийн газар нээх хүсэлт гаргахдаа дараах баримт бичгийг бүрдүүлж Хороонд ирүүлнэ:

3.30.1. Төлөөлөгчийн газар байгуулах тухай хүсэлт;

3.30.2. Төлөөлөгчийн газар байгуулах тухай компанийн Төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал/-ийн шийдвэр;

3.30.3. Компаниас баталсан төлөөлөгчийн газрын үйл ажиллагаанд мөрдөх журмын төсөл;

3.30.4. Төлөөлөгчийн газрын удирдлага, боловсон хүчний талаарх тодорхойлолтыг ирүүлэх /энэ журмын 3 дугаар хавсралтаар гаргах/

3.30.5. Төлөөлөгчийн газрын жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө;

3.30.6. Төлөөлөгчийн газрын үйл ажиллагаа явуулах ажлын байрны талаарх мэдээлэл, холбогдох баримт бичиг;

3.30.7. Төлөөлөгчийн газрын үйл ажиллагаанд ашиглах тоног төхөөрөмж, программ хангамжийн талаарх мэдээлэл;

3.30.8. Шаардлагатай гэж үзвэл Хороо нэмэлт материал шаардаж болно.

3.31. Даатгалын байгууллага нь энэ журамд заасан даатгалын салбар, төлөөлөгчийн газар байгуулахаас өөр аливаа нэгж байгуулахыг хориглоно.

3.32. Хороо энэ журмын 3.30-д дурдсан баримт бичгийг хянан үзэж, даатгалын төлөөлөгчийн газар байгуулах нь тухайн хуулийн этгээдийн санхүүгийн чадварт сөргөөр нөлөөлөхгүй, даатгуулагчдын эрх ашигт хохирол учруулахгүй гэж үзсэн, боловсон хүчин, техник тоног төхөөрөмж нь тухайн төлөөлөгчийн газрын үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөлийг хангаж байна гэж үзвэл зөвшөөрөл олгох шийдвэрийг Хорооны дарга гаргана.

3.33. Даатгалын байгууллага нь төлөөлөгчийн газар нээх, татан буулгах, үйл ажиллагааг хязгаарлах, өөрчлөн байгуулах (нэгтгэх, нийлүүлэх, салгах, тусгаарлах, өөрчлөх), байршлыг нь өөрчлөх (хооронд нь солих, шилжүүлэх) тухай бүрд шийдвэр гаргаж, уг шийдвэрийг гаргасан өдрөөс хойш ажлын 3 хоногийн дотор Хороонд бичгээр мэдэгдэнэ.

3.34. Хорооны даргын шийдвэр болон зохицуулалтын үйлчилгээний хөлс төлсөн баримтыг үндэслэн тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хавсралтад төлөөлөгчийн газрын талаарх тэмдэглэлийг хийж баталгаажуулна.

3.35. Даатгалын байгууллагын төлөөлөгчийн газар нээх зөвшөөрлийг дараах үндэслэлээр хүчингүй болгож, тусгай зөвшөөрлийн гэрчилгээнд ажлын 5 хоногийн дотор энэ тухай тэмдэглэл хийнэ. Үүнд:

3.35.1. Хорооны шийдвэрээр;

3.35.2. Даатгалын байгууллагын шийдвэрээр;

3.35.3. Хууль тогтоомжид заасан бусад үндэслэл”.

3.36. Даатгалын компанийн төлөөлөгчийн газар нээх гэж буй аймаг, дүүрэгт албан ёсны зөвшөөрөл бүхий салбартай бол тухайн төлөөлөгчийн газар нь даатгалын гэрээ байгуулж болох бөгөөд тухайн аймаг, дүүрэгт салбаргүй бол төлөөлөгчийн газар нь даатгалын гэрээ байгуулахыг хориглоно. */Энэ бүлгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн 158 дугаар тогтоолоор нэмсэн/*

## **ДӨРӨВ. ХЯНАЛТ, ХАРИУЦЛАГА**

4.1. Энэ журмаар тавьсан аливаа шаардлагын биелэлтийн тайланг даатгалын байгууллага нь жил бүрийн 1 дүгээр улиралд багтаан гаргаж Хороонд ирүүлнэ.

4.2. Хорооны зөвшөөрөлгүй компанийн дүрмийн сангийн бүтцэд өөрчлөлт оруулж гүйлгээ хийсэн нөхцөлд тухайн гүйлгээг буцааж, буруутай этгээдэд холбогдох хуулийн дагуу Хороо хариуцлага хүлээлгэнэ.

4.3. Хороо нь энэ журмын биелэлтэд хяналт тавьж, газар дээр нь шалгалт хийж, хууль тогтоомж зөрчсөн этгээдэд Аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 18.1, Даатгалын тухай

хуулийн 83.1 болон Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 45.1-д тус тус заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

--ooOoo--



“Ердийн даатгал, давхар даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ын 1 дүгээр хавсралт  
*Энэ хавсралтад Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 387 дугаар тогтоолоор нэмэлт оруулсан/*

ЕРДИЙН ДААТГАЛ, ДАВХАР ДААТГАЛЫН БОЛОН ДААТГАЛЫН  
МЭРГЭЖЛИЙН ОРОЛЦОГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ  
ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ХҮССЭН ӨРГӨДӨЛ

Огноо: .....

Хаана: Санхүүгийн зохицуулах хороо,

Засгийн газрын IY байр,

Бага тойруу-6, Улаанбаатар-46,

Монгол улс

Хаанаас: .....

.....

(Өргөдөл гаргагчийн нэр, хаяг, утас, факс, и-мэйл хаяг)

.....

(Ердийн даатгал, давхар даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн нэр)

Хуулийн этгээдийн үүсгэн байгуулагчид хурал хийж, дор дурдсан үйл ажиллагаа эрхлэхээр шийдвэрлэсэн болно. Үүнд:

Эрхлэх үйл ажиллагааны төрөл: .....

(даатгалын үйл ажиллагаа, даатгалын зуучлагч, даатгалын хохирол үнэлэгч, давхар даатгалын үйл ажиллагаа)

Даатгалын ангилал: .....

Даатгалын хэлбэр бүтээгдэхүүн: 1.....

2.....

3.....

Ердийн даатгал, давхар даатгал болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэхэд дараах хуулийн этгээд, үүсгэн байгуулагч, иргэд тус компанид хөрөнгө оруулахаар шийдвэрлэв:

| № | Овог, нэр<br>(Хуулийн этгээдийн нэр) | Регистрийн дугаар | Иргэний үнэмлэхийн дугаар<br>(Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар) | Хаяг | Хувь нийлүүлэх хөрөнгийн хэмжээ<br>(мянган төгрөг) |
|---|--------------------------------------|-------------------|---|------|--|
|---|--------------------------------------|-------------------|---|------|--|

Компанийн үүсгэн байгуулагч (үүсгэн байгуулагчид) нь өөрийн хууль ёсны өмчлөлд байгаа мөнгөн хөрөнгөөр хувь нийлүүлсэн болно.

Компанийн гүйцэтгэх удирдлагад (гүйцэтгэх захирал, нэгжийн удирдлага, ерөнхий нягтлан бодогч) энэ журмын шаардлагыг хангасан дараах хүмүүс ажиллах болно. Үүнд:

| № | Овог, нэр | Одоогийн эрхэлж буй ажил | Регистрийн дугаар | Иргэний үнэмлэхийн дугаар<br>(Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар) | Компанид эрхлэх албан тушаал |
|---|-----------|--------------------------|-------------------|---|------------------------------|
|---|-----------|--------------------------|-------------------|---|------------------------------|



“Ердийн даатгал, давхар даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ын 2 дугаар хавсралт

ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ, ХУВЬ НИЙЛҮҮЛЭГЧ, ТУЗ-ИЙН ДАРГА,  
ГИШҮҮНИЙ ТОДОРХОЙЛОЛТ

А. Тухайн хуулийн этгээдэд ямар холбоотой болохыг тэмдэглэнэ үү.

1. Үүсгэн байгуулагч:
2. Хувь нийлүүлэгч:
3. Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга:
4. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн:

Б. Үүсгэн байгуулагч, хувь нийлүүлэгчийн талаар

1. Үүсгэн байгуулагч, хувь нийлүүлэгч нь:

- Хуулийн этгээд
- Иргэн

2. Хувь нийлүүлсэн мөнгөн хөрөнгийн хэмжээ:

..... төгрөг

(тоогоор) (үсгээр)

3. Хувь нийлүүлэгч нь хуулийн этгээд бол дараах мэдээллийг үнэн зөв бичиж ирүүлнэ:

- Оноосон нэр:
- Байгуулагдсан он сар:
- Үйл ажиллагаа эрхлэх хугацаа:
- Байршил буюу хаяг:
- Улсын бүртгэлийн дугаар:
- Регистрийн дугаар:
- Хувь нийлүүлэгчдийн овог нэр:
- Регистрийн дугаар:
- Удирдлагын овог нэр:
- Регистрийн дугаар:
- Эрхлэх үйл ажиллагааны төрөл:
- Дүрмийн санг бүрдүүлсэн хөрөнгийн танилцуулга, тодорхойлолт:

(Хуулийн этгээдийн нэр)..... нь ..... (даатгалын компани, давхар даатгалын компани, зуучлагч компани, хохирол үнэлгээний компани)-ийн хувь нийлүүлэгч болж, тус компанийн дүрмийн санд оруулж байгаа ..... (үсгээр) төгрөг нь манай хуулиар зөвшөөрөгдсөн үйл ажиллагаанаас олсон цэвэр ашгаас бүрдэж байгаа бөгөөд холбогдох материалыг үнэн зөвөөр хууль тогтоомжийн дагуу бүрдүүлэн Хороонд хүргүүлсэн болохоо нотлохын зэрэгцээ үүнээс үүсэх аливаа эрсдэлийг хууль тогтоомжийн дагуу бүрэн хариуцахаа илэрхийлж байна.

4. Хувь нийлүүлэгч нь иргэн бол дараах мэдээллийг үнэн зөв бичиж ирүүлнэ:

- Овог нэр:
- Төрсөн он сар:
- Иргэний харьяалал:
- Гэрийн хаяг:
- Иргэний үнэмлэхийн дугаар:
- Регистрийн дугаар:

- Эрхэлж буй ажил (хугацаа, хаяг):
- Боловсролын талаар (ерөнхий боловсролын сургуулийг оролцуулан бичнэ):

| № | Төгссөн сургууль | Эзэмшсэн мэргэжил | Элссэн он | Төгссөн он | Диплом, гэрчилгээний дугаар |
|---|------------------|-------------------|-----------|------------|-----------------------------|
|   |                  |                   |           |            |                             |

- Ажлын туршлага:

| Хаана ажиллаж байсан | Албан тушаал | Ажилд орсон он сар өдөр | Ажлаас гарсан он сар өдөр | Шалтгаан |
|----------------------|--------------|-------------------------|---------------------------|----------|
|                      |              |                         |                           |          |

5. Үүсгэн байгуулагч, хувь нийлүүлэгчийн холбогдох этгээдийн байдал:

| № | Таны юу болох | Овог нэр | Регистрийн дугаар | Иргэний үнэмлэхийн дугаар | Эрхэлж буй ажил |
|---|---------------|----------|-------------------|---------------------------|-----------------|
|   |               |          |                   |                           |                 |

Холбогдох этгээдийн товч танилцуулгад урьд өмнө эрхэлж байсан ажил, төрлийн байдал аль нэг хуулийн этгээдийг төлөөлдөг эсэх, түүний үйл ажиллагаа, байршил, бусдад өр зээлтэй эсэх, одоо хууль хяналтын байгууллагад хэрэг үүсгэгдэн шалгагдаж байгаа эсэх зэргийг бичнэ.

Тодорхойлолт гаргасан:

..... (иргэн, эсхүл байгууллагын удирдлагын гарын үсэг) ..... (овог нэр)

.....компанийг төлөөлж..... (албан тушаал)

“Ердийн даатгал, давхар даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ын 3 дугаар хавсралт

**Даатгалын байгууллагын гүйцэтгэх удирдлага, салбарын удирдлага болон бусад боловсон хүчний тодорхойлолт**

1. Даатгалын байгууллагын гүйцэтгэх удирдлага, салбарын удирдлага болон бусад боловсон хүчин нь дараах мэдээллийг үнэн зөв бичиж, ирүүлнэ. Үүнд:

- Овог нэр
- Эрхлэх албан тушаал
- Төрсөн он сар өдөр
- Иргэний харъяалал
- Гэрийн хаяг
- Утасны дугаар
- Иргэний үнэмлэхний дугаар (нэмлэхийн баталгаажуулсан хуулбарыг хавсаргах)
- Регистрийн дугаар
- Одоо эрхэлж байгаа ажил:
  - хугацаа
  - хаяг
- Боловсролын талаар (ерөнхий боловсролын сургуулийг оролцуулан бичнэ):

| № | Төгссөн сургууль | Эзэмшсэн мэргэжил | Элссэн он | Төгссөн он | Диплом, гэрчилгээний дугаар |
|---|------------------|-------------------|-----------|------------|-----------------------------|
|---|------------------|-------------------|-----------|------------|-----------------------------|

• Ажлын туршлагын талаар:

| № | Хаана ажиллаж байсан | Албан тушаал | Ажилд орсон он сар | Ажлаас гарсан он сар өдөр | Шалтгаан |
|---|----------------------|--------------|--------------------|---------------------------|----------|
|---|----------------------|--------------|--------------------|---------------------------|----------|

• Гүйцэтгэх удирдлага, боловсон хүчний товч танилцуулга (аль нэг хуулийн этгээдийг төлөөлдөг эсэх, түүний үйл ажиллагаа, өөр аль нэг хуулийн этгээдийн үүсгэн байгуулагч, хувь нийлүүлэгч эсэх, бусдад өр, зээлтэй эсэх, одоо хууль хяналтын байгууллагад хэрэг үүсгэгдэн шалгагдаж байгаа эсэх зэргийг бичнэ).

2. Гүйцэтгэх удирдлага, боловсон хүчний яаралтай үед холбоо барих холбогдох этгээдийн байдал:

| № | Танай юу болох | Овог нэр | Регистрийн дугаар | Иргэний үнэмлэхийн дугаар | Эрхэлж буй албан тушаал |
|---|----------------|----------|-------------------|---------------------------|-------------------------|
|---|----------------|----------|-------------------|---------------------------|-------------------------|

.....-г төлөөлж .....

(албан тушаал)

.....

(гарын үсэг)

.....

(овог, нэр)

“Ердийн даатгал, давхар даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ын 4 дүгээр хавсралт

**ПРОГРАММ ХАНГАМЖ, ТЕХНИК ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ,  
АЖЛЫН БАЙРНЫ ТОДОРХОЙЛОЛТ**

Ердийн даатгал, давхар даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх компанийн үйл ажиллагаанд ашиглах техник, тоног төхөөрөмжийг дараах байдлаар тодорхойлж байна. Үүнд:

| № | Тоног төхөөрөмжийн төрөл | Техникийн үзүүлэлт | Худалдан авсан, түрээсэлсэналинболох | Тоо ширхэг |
|---|--------------------------|--------------------|--------------------------------------|------------|
|---|--------------------------|--------------------|--------------------------------------|------------|

Компани нь дээрх тоног төхөөрөмж, техник хэрэгслээс гадна нягтлан бодох бүртгэлийн

.....  
(программ, түүнийг зохиосон байгууллагын нэр) программ, даатгалын мэдээллийн санд мэдээ өгч, авах зориулалт бүхий .....

(программ, түүнийг зохиосон байгууллагын нэр) программ, болон

.....-г (худалдан авсан, худалдан авах гэж байгаа, эсхүл гэрээ хийсэн байгаа эсэхийг бичих) бөгөөд өдөр тутмын мэдээ, мэдээлэл боловсруулалтын ажилд компьютерийн

.....  
(программ, түүнийг зохиосон байгууллагын нэр) программ ашиглах болно.

Үйл ажиллагаа явуулах байрыг:

- Худалдан авсан
- Түрээсэлсэн.

Энэхүү байр нь даатгалын үйл ажиллагаа эрхлэхэд тохиромжтой болно.

- Худалдан авсан байрны үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн гэрчилгээ
- Түрээсэлсэн байрны түрээсийн гэрээний хуулбарыг хавсаргав.

.....компанийг төлөөлж .....

(албан тушаал)

.....  
(гарын үсэг)

.....  
(овог, нэр)

“Ердийн даатгал, давхар даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ын 5 дугаар хавсралт

## **БИЗНЕС ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ ЗӨВЛӨМЖ**

1. Бизнес төлөвлөгөө гэж нь компанийн стратеги, зорилтыг тодорхойлж, компанийн үйл ажиллагааг эрхлэхэд түүний бүтэц, зохион байгуулалт, үйлчилгээний шуурхай, найдвартай ажиллагаа, удирдлагын ур чадвар, санхүү, төлбөрийн чадварын үзүүлэлт, үр ашгийг жил тутам сайжруулах чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхой цаг хугацаагаар төлөвлөн боловсруулсан баримтыг хэлнэ.

2. Компани нь бизнес төлөвлөгөөг өөрийн үйл ажиллагааны онцлогтой уялдуулан дараахь асуудлуудыг тусгасан байна. Үүнд:

2.1 Компанийн үйл ажиллагааны зорилго, зорилт

2.2 Компанийн үйл ажиллагаа эрхлэхэд ашигтай байх макро болон микро түвшин дэх боломжит нөхцөлүүд

2.3 Компанийн тайлан тэнцэл, мөнгөн хөрөнгийн урсгал, орлого зарлагын 3 жилийн төсөөлөл

2.4 Ердийн даатгалаар хамгаалах эрсдлийн төрөл, түүнээс урьдчилан сэргийлэх

2.5 Үйл ажиллагаатай холбогдон гарах эрсдэлийг тодорхойлж, түүнийг удирдахад авах арга хэмжээ

2.6 Давхар даатгалын төлөвлөгөө

2.7 Компанийн засаглалыг боловсронгуй болгох, сайжруулах төлөвлөгөө

2.8 Хөрөнгө оруулалтын төлөвлөгөө.

3. Бизнес төлөвлөгөөг компанийн үйл ажиллагаа эрхлэн явуулж эхэлснээс хойш 3-5 жилийн хугацаанд хэрэгжүүлэхээр төлөвлөн боловсруулна.

4. Бизнес төлөвлөгөө нь дараах хэсгээс бүрдэнэ. Үүнд:

### **I. ГҮЙЦЭТГЭЛИЙН ХУРААНГУЙ**

Энэ бүлэгт тухайн бизнес төлөвлөгөөг хэрэгжүүлэгч нь хэрэгжүүлэх гэж буй бизнес төлөвлөгөөний эрхэм зорилго, зорилт, амжилтын үндэс, учирч болох эрсдэл болон санхүүгийн бусад үзүүлэлтүүдийн тухай товч мэдээллийг багтаана.

Эрхэм зорилго гэдэг нь үйлчлүүлэгч, даатгуулагчдын ямар хэрэгцээг, ямар арга замаар хангах тухай тодорхойлолт юм.

Зорилт гэдэг нь эрхэм зорилтонд хүрэхийн тулд шат дараалан хэрэгжүүлэх, хугацаатай, хэмжигдэхүйц бодитой үр дүн буюу хүрэх цэг юм.

### **II. БИЗНЕСИЙН ТАНИЛЦУУЛГА**

Бизнесийн танилцуулга гэдэг нь тухайн компанийн нэр, хаяг, хариуцлагын тогтолцоо, зах зээлийн нөхцөл төлөв байдал, эрхлэх гэж буй даатгалын үйл ажиллагаа, гаргаж буй үйлчилгээ түүнчлэн удирдлага боловсон хүчний хангалт, санхүүгийн чадавхи ба байдал бизнес төлөвлөгөө бичих болсон шалтгаан, зорилго зорилтууд түүнийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийн эх үүсвэр, үйл ажиллагааны үр ашиг, борлуулалтын орлого, ашиг зэргийг тусган харуулсан хураангуй тодорхойлолт юм.

Бизнесийн танилцуулга нь дараах үндсэн хэсгүүдээс бүрдэнэ:

- Бизнес ба түүний түүх
- Зах зээлийн нөхцөл төлөв байдал
- Эрхлэх гэж буй даатгалын үйл ажиллагаа
- Эрхлэх гэж буй даатгалын хэлбэрийн дэлгэрэнгүй

- Даатгалын хураамж
- Нөхөн төлбөр олголт
- Удирдлага, боловсон хүчин
- Санхүүгийн байдал төлөв

### III. МАРКЕТИНГИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

**Бизнес төлөвлөгөөний "маркетингийн төлөвлөгөө"-нд дараах гурван хэсгийг оруулна.**

#### 3.1. Зах зээлийн шинжилгээ

Маркетингийн төлөвлөгөөг боловсруулахын тулд юуны түрүүнд зах зээл буюу хэрэглэгчдийнхээ тухай судалж мэдэх, зах зээлийн өрсөлдөгчид, танайд бараа үйлчилгээ үзүүлэх түншүүд, зуучлагчдынхаа талаар судлах ёстой.

#### 3.2. Маркетингийн стратеги

Маркетингийн стратеги гэдэг нь зах зээл рүү хандсан төлөвлөгөө буюу амжилт олохын тулд танай байгууллагын хэрэглэж буй арга замууд юм.

#### 3.3. Маркетингийн иж бүрдэл

Танай компани зах зээл рүүгээ хандах арга зам буюу стратегиа тодорхойлсон бол одоо зах зээл дээр таатай нөхцөл байдал үүсгэхийн тулд байгууллагын ашигладаг хүчин зүйлс буюу маркетингийн иж бүрдлийг хэрхэн бүрдүүлэх вэ? Маркетингийн иж бүрдэлд үйлчилгээ, үнэ, идэвхжүүлэлт, хуваарилалтын талаар тусгана.

### IV. МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

**Бизнес төлөвлөгөөний энэ бүлэгт удирдлага, зохион байгуулалт, боловсон хүчний хэрэгцээ гэсэн асуудлуудыг багтааж оруулна.**

**Удирдах баг:** Бизнес төлөвлөгөөний энэ хэсэгт удирдлага нь тухайн чиглэлээр хэр мэргэшсэн, бие биенээ орлох чадвар нь ямар болох, мэргэжил дадлага туршлагатай байх шаардлагыг хэр зэрэг хангасан байдал болон эрх мэдэл, ажил үүргийг оновчтой хуваарилсан байдал зэргийг харуулах хэрэгтэй.

**Зохион байгуулалтын бүтэц:** Зохион байгуулалтын шат дамжлага багатай, хамгийн үр ашигтай бүтцийг тогтоон, удирдлага мэдээллээр сайн хангагддаг байх, ажиллагчид ажлынхаа үр дүнг сонирхдог байх, хяналт ил тод байна.

**Боловсон хүчин:** Энэ хэсэгт шаардагдлагатай мэргэжлийн боловсон хүчин тэдгээрийн тоо түүнчлэн мэргэжил эзэмшүүлэх эсвэл мэргэжил дээшлүүлэх сургалтын асуудлуудыг төлөвлөх болно.

Энэ хэсэгт нийт ажиллагчид болон шаардагдлагатай мэргэжлийн боловсон хүчний хэрэгцээ, уг ажлыг гүйцэтгэх ажиллагсдын тоо түүнчлэн нийт ажиллагсдын сар, жилийн цалингийн хэмжээ, цалингийн шимтгэлийг тооцоолж төлөвлөнө.

### V. САНХҮҮГИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Санхүүгийн төлөвлөгөөнд дараах хэсгүүд орно. Үүнд :

- Нийт орлогын тооцоо
- Үйлажиллагааны урсгал зардлын тооцоо, давхар даатгалын хураамж, нөхөн төлбөр, нөөцийн сангийн тооцоо
- Үндсэн ба үндсэн бус үйл ажиллагааны, хөрөнгө оруулалтын Ашиг/ алдагдлын тооцоо
- Алдагдалгүй ажиллагааны тооцоо
- Мөнгөн урсгалын тооцоо гэх мэт.



## ҮІ. ЭРСДЭЛИЙН ШИНЖИЛГЭЭ

### **6.1.Эрсдэлийн төрлүүд:**

Компанийн үйл ажиллагааны эрсдлийг техник, тоног төхөөрөмжийн, даатгалын гэрээний эрсдэл, давхар даатгалын эрсдэл, санхүүгийн, хүний хүчин зүйлийн, хууль зүйн, зах зээлийн гэх мэтээр ангилан шинжилгээ хийнэ.

### **6.2.Эрсдэлийг багасгах боломжууд**

Эдгээр дурьдсан эрсдэлээс чухам ямар нь танай бизнест тохиолдож болох магадлал илүү вэ? Түүнийг доод хэмжээнд байлгахын тулд та ямар арга хэмжээ төлөвлөснөө бичнэ.

Эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авсны дүнд компанийн ашигт ажиллагаа хэрхэн хадгалагдаж үлдэхийг төлөвлөсөн үр дүнтэй жишиж харьцуулаарай.

## ҮІІ. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

7.1 Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг эрсдэлийн шинжилгээтэй уялдуулан дэлгэрэнгүйгээр боловсруулна.

7.2 Хөрөнгийг хөрөнгө оруулах гэж буй зүйлийн ангилал тус бүрээр дэлгэрэнгүй гаргана.

## ҮІІІ. ДАВХАР ДААТГАЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Давхар даатгалын төлөвлөгөө нь Хорооны 2007 оны 65 дугаар тогтоолоор батлагдсан “Датгагчийн давхар даатгалын төлөвлөгөөнд тавигдах шаардлага, түүнд хяналт тавих журам”-д нийцсэн байдал зохино.

Давхар даатгалын төлөвлөгөөнд дараах зүйлийг тусгасан байвал зохино. Үүнд:

8.1 Даатгагчийн эрсдэл даах чадвар

8.2 Давхар даатгалын талаарх мэдээлэл,

8.3 Давхар даатгагчийг хэрхэн сонгох болон тэдний аюулгүй байдлыг хэрхэн үнэлэх талаар,

8.4 Давхар даатгалын төлөвлөгөөнд хэрхэн хяналт тавих талаар (мэдээллийн болон дотоод хяналтын системийн талаар)

8.5 Давхар даатгалын ямар хэлбэр нь тухайн даатгагчийн эрсдэлд тохиромжтой байгаа талаар

8.6 Бусад.

“Ердийн даатгал, давхар даатгалын олон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ын 6 дугаар хавсралт

ДААТГАЛЫН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ  
ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ХҮССЭН ӨРГӨДӨЛ

Огноо: .....

Хаана: Санхүүгийн зохицуулах хороо,

Засгийн газрын IY байр,

Бага тойруу-6, Улаанбаатар-46,

Монгол улс

Хэнээс:.....

.....

(өргөдөл гаргагчийн овог нэр, хаяг, утас, факс, и-мэйл хаяг)

Иргэн ..... би дор дурдсан даатгалын хэлбэрийн даатгалын төлөөлөгчөөр ажиллахаар шийдвэрлэсэн болно.

Үүнд:

1.....

2.....

3.....

Монгол Улсын Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, Даатгалын тухай хууль, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан “Ердийн даатгал, давхар даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох журам”-д нийцүүлэн даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авахад шаардагдах баримт бичгийг үнэн зөв бүрдүүлж, хүргүүлэв. Бүрдүүлсэн баримт бичигт ямар нэг худал ташаа зүйл орсон байвал хариуцлагыг би хүлээх болно.

Миний өргөдөл материалыг хүлээн авч, хянан шийдвэрлэж, даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгож өгнө үү.

ӨРГӨДӨЛ ГАРГАГЧ:

.....

(гарын үсэг)

(овог, нэр

Санхүүгийн зохицуулах хорооны  
2008 оны 61 дүгээр тогтоолын  
тогтоолын 7 дугаар хавсралт  
/Энэхүү хавсралтад Санхүүгийн зохицуулах хорооны  
2012 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн  
158 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан/

МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

**ЕРДИЙН ДААТГАЛ, ДАВХАР ДААТГАЛ БОЛОН ДААТГАЛЫН  
МЭРГЭЖЛИЙН ОРОЛЦОГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ  
ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭ**

200... оны ... сарын ... өдөр

Дугаар ...

Улаанбаатар хот

Монгол Улсын “Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль”, “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль”, “Даатгалын тухай хууль”, “Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль”, Санхүүгийн зохицуулах хорооны .....оны .....дугаар тогтоолоор батлагдсан “Ердийн даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-н шаардлагыг хангасан бүрэн хангасан гэж үзэж Санхүүгийн зохицуулах хорооны .....оны.....сарын.....өдрийн.....дугаар тогтоолоор

.....  
(хуулийн этгээдийн оноосон нэр)

оноосон нэр бүхий .....компанид даатгалын  
.....үйл ажиллагаа  
эрхлэхийг зөвшөөрсөн тул энэхүү гэрчилгээг олгов.

ДАРГА

Тамга

Энэхүү гэрчилгээ нь хавсралтын хамт хүчинтэй.

**1. Даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчид зориулсан тэмдэглэлүүд:**

**НЭГ.** Даатгалын байгууллагын оноосон нэр:.....

**ХОЁР.** Тусгай зөвшөөрлийн төрөл.....  
(даатгагч, давхар даатгагч, даатгалын зуучлагч, хохирол үнэлэгч)

**ГУРАВ.** Эрхлэх даатгалын ангилал:.....

**ДӨРӨВ.** Компанийн хаягийн өөрчлөлтүүд:

| № | Хаяг: | Утас |
|---|-------|------|
|   |       |      |

**ТАВ.** Хувьцаа эзэмшигчийн талаарх тэмдэглэл:

| № | Овог нэр /Хуулийн этгээдийн нэр/ | Регистерийн дугаар | Хөрөнгийн хэмжээ | Хөрөнгийн хувь | Зөвшөөрөл олгосон |
|---|----------------------------------|--------------------|------------------|----------------|-------------------|
|   |                                  |                    |                  |                |                   |

**ЗУРГАА.** Эрхлэх даатгалын хэлбэрийн талаарх тэмдэглэл:

| №   | Эрхлэх даатгалын хэлбэр | Бүтээгдэхүүн | Тусгай зөвшөөрөл олгосон огноо | Түдгэлзүүлсэн огноо | Хүчингүй болгосон огноо |
|-----|-------------------------|--------------|--------------------------------|---------------------|-------------------------|
| 1.  |                         |              |                                |                     |                         |
| 2.  |                         |              |                                |                     |                         |
| 3.  |                         |              |                                |                     |                         |
| 4.  |                         |              |                                |                     |                         |
| 5.  |                         |              |                                |                     |                         |
| 6.  |                         |              |                                |                     |                         |
| 7.  |                         |              |                                |                     |                         |
| 8.  |                         |              |                                |                     |                         |
| 9.  |                         |              |                                |                     |                         |
| 10. |                         |              |                                |                     |                         |

|     |  |  |  |  |  |
|-----|--|--|--|--|--|
| 11. |  |  |  |  |  |
| 12. |  |  |  |  |  |
| 13. |  |  |  |  |  |
| 14. |  |  |  |  |  |

ДОЛОО. Нэгжийн тэмдэглэл:

| № | Нэгжийн нэр дугаар | Нэгжийн хаяг | Нэгжид зөвшөөрөл олгосон шийдвэр, он, сар, өдөр | Бусад тэмдэглэл / татан буугдсан, зөвшөөрлийг хүчингүй болгосон, өөрчилсөн хаяг |
|---|--------------------|--------------|---|---|
|---|--------------------|--------------|---|---|

НАЙМ. Дүрмийн сангийн өөрчлөлтийн талаар:

| № | Дүрмийн сангийн нэмэгдүүлсэн, хорогдуулсан хэмжээ | Зөвшөөрөл авсан огноо | Дүрмийн сангийн хэмжээ |
|---|---|-----------------------|------------------------|
|---|---|-----------------------|------------------------|

|  |  |  |  |  | Огноо | Шийдвэрийн дугаар, тэмдэг |
|--|--|--|--|--|-------|---------------------------|
|--|--|--|--|--|-------|---------------------------|

ЕС. Бусад нэмэлт, өөрчлөлт:

.....  
 .....

*Санхүүгийн зохицуулах хорооны  
2008 оны 61 дүгээр тогтоолын  
тогтоолын 8 дугаар хавсралт  
/Энэхүү хавсралтад Санхүүгийн зохицуулах хорооны  
2012 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн  
158 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан/  
  
/Энэхүү хавсралтад Санхүүгийн зохицуулах хорооны  
2013 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн  
93 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан/  
  
/Энэхүү хавсралтад Санхүүгийн зохицуулах хорооны  
2015 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн  
275 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан/*



МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

Дугаар

3\*4  
хэмжээтэй  
Зураг

\_\_\_\_\_ ХХК-ийн  
даатгалын төлөөлөгчөөр ажиллах тусгай  
зөвшөөрөл олгов.

Санхүүгийн зохицуулах хорооны Ажлын  
албаны дарга

Б.Батсэлэнгэ

Олгосон огноо \_\_\_\_\_

\_\_\_\_\_ овогтой

“Тэмдэг”

Санхүүгийн зохицуулах хорооны  
2008 оны 61 дүгээр тогтоолын  
9 дүгээр хавсралт  
/Энэхүү хавсралтыг Санхүүгийн зохицуулах хорооны  
2012 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн  
158 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан/

МОНГОЛ УЛС



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

**ДААТГАЛЫН БАЙГУУЛЛАГЫН НЭГЖИЙН ГЭРЧИЛГЭЭ**

Дугаар ...

200... оны ... сарын ... өдөр

Монгол Улсын “Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль”,  
“Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль”, “Даатгалын тухай хууль”,  
“Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль”, Санхүүгийн зохицуулах хорооны  
.....оны .....дугаар тогтоолоор батлагдсан “Ердийн даатгалын болон даатгалын  
мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ын  
шаардлагыг хангасан тул Санхүүгийн зохицуулах хорооны даргын \_\_\_\_\_оны  
\_\_\_\_\_сарын \_\_\_\_\_өдрийн \_\_\_\_\_дугаар \_\_\_\_\_тушаалыг  
үндэслэн \_\_\_\_\_хот/аймаг дахь \_\_\_\_\_тоот регистрийн  
дугаар \_\_\_\_\_бүхий \_\_\_\_\_тоот \_\_\_\_\_улсын \_\_\_\_\_бүртгэлийн  
гэрчилгээтэй \_\_\_\_\_оноосон нэр бүхий Даатгалын  
байгууллагад \_\_\_\_\_хот/аймгийн \_\_\_\_\_  
\_\_\_\_\_дүүрэг/сум/нд \_\_\_\_\_

байгу

улахыг зөвшөөрч, энэхүү гэрчилгээг олгов.

ДАРГА  
“Тэмдэг”